



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/494

Мандалговь

Аэродромын аюулгүйн бүс тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.5, Иргэний нисэхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, Зам тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/56 тоот тушаал, Зам тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/131 тоот тушаалаар батлагдсан "Аэродромын төлөвлөлт ба ашиглалт" техникийн баримт бичгийн 7.5.3, 7.5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймгийн Сайнцагаан сумын нутагт орших Иргэний Нисэхийн Үндэсний Төвийн харьяа "Мандалговь" нисэх буудлын аэродромын аюулгүйн бүс болох "Тусгай бүс" "Агаарын хөлгийн ойртолтын бүс" аэродром орчмын "Аюулгүйн А болон Б бүс" ийн зургийг нэгдүгээр хавсралтаар, хязгаарын цэгийн солбилцлуудыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аэродром орчмын аюулгүйн бүсийн талбайг зориулалтын дагуу аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгуулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих, аэродромын "Тусгай бүс" буюу агаарын хөлгийн буулт, хөөрөлтийн чиглэлд хөөрч буух зурвасны босгоос хоёр тийш 4000 метр урт, хөөрч буух зурвасны тэнхлэгээс хоёр тийш 1000 метр буюу нийт 2000 метрийн өргөнтэй тэгш өнцөгт талбайд газар олгохгүй байх, өмнө олгогдсон газарт барилга байгууламж барих тохиолдолд Иргэний нисэхийн ерөнхий газар, "Мандалговь" нисэх буудалтай урьдчилан зөвшилцөж, нисэхийн аюулгүй байдлыг хангасан шийдвэр гаргаж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж)-т даалгасугай.

3. Аэродром орчмын "Аюулгүйн А болон Б бүс"-д иргэн, аж ахуйн нэгжийн явуулж буй үйл ажиллагаа нь "Аэродромын төлөвлөлт ба ашиглалт" техникийн баримт бичгийн 7.5.1, 7.5.2 дахь заалтыг хангаж, нисэхийн аюулгүй ажиллагаанд нөлөөлж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга (С.Бат-Оргил), "Мандалговь" нисэх буудлын дарга (Г.Буянбат)-д тус тус үүрэг болгосугай.

4. Аэродромын "Тусгай бүс"-ийг тэмдэгжүүлж ажиллахыг "Мандалговь" нисэх буудлын дарга (Г.Буянбат)-д даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Л.Доржбат), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат), Мандалговь нисэх буудлын дарга (Г.Буянбат)-д тус тус үүрэг болгосугай.

6. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/373 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



М.АНХБАЯР

431210614